




УДИРДАМЖ

2025 оны 09 дүгээр сарын 23

Дугаар: 03 (2025)

Улаанбаатар хот

Музейн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журмын
хэрэгжилтэд үзлэг шалгалт хийх тухай

Нэг. Үндэслэл: Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” 311 дүгээр тогтоол, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (цаашид ХАБЭА гэх)-н тухай хууль, Улаанбаатар хотын музейн ХАБЭА-н хяналтын журам, 2025 оны музейн дотоод хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөө, Улаанбаатар хотын музейн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

Хоёр. Зорилго: Улаанбаатар хотын музейн ХАБЭА хариуцсан ажилтны ХАБЭА-н журмын дагуу зохион байгуулж буй ажилд үзлэг явуулж, үзлэгийн илтгэх хуудас бичиж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан музейн удирдлагад танилцуулж, музейн ХАБЭА-н ажлыг боловсронгуй болгоход оршино.

Гурав. Зорилт: Улаанбаатар хотын музейн ХАБЭА хариуцсан ажилтны зохион байгуулж буй ажилд үзлэг шалгалт явуулах

Дөрөв. Шалгалтын бүрэлдэхүүн:

Дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтан, менежер

Тав. Хяналт шалгалт явуулах хугацаа:

2025 оны 09 дүгээр сарын 25 (ажлын нэг өдөр)

Зургаа. Хамрах хүрээ: Улаанбаатар хотын музейн бүх үйл ажиллагаанд ХАБЭА-н журмын хэрэгжилт

Долоо. Шалгалт явуулах чиглэл:

7.1.ХАБЭА-н тухай хууль

14.1.Ажил олгогч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулна.

14.2.Энэ хуулийн 14.1-д заасны дагуу эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч хариуцна.

15.1.Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй.

26.2.Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшнээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна.

27 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц, зохион байгуулалт

27.1.Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна.

27.2.Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна.

7.2.Улаанбаатар хотын музейн ХАБЭА-н журам

2.2.Музейн нь ХАБЭА-н орон тооны бус 2 ажилтныг захирлын тушаалаар томилж, ажиллуулна. ХАБЭА-н орон тооны бус ажилтан нь Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА-н зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам"-ыг жишиг болгон ХАБЭА-н ажилтны ажиллах журмыг боловсруулан баталж, мөрдөнө.

2.4.Тушаалаар томилогдсон ажилтан ХАБЭА-н холбогдох хууль тогтоомж, дүрэм, заавар стандарт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангуулж ажиллана.

7.1.1.8.Ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх;

7.1.1.9.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэх;

7.2.ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан дараах нийтлэг эдлэх эрх, үүрэг хүлээнэ. /ХАБЭА-н тухай хуулийн 27.3/

7.2.1.Хүлээх үүрэг:

7.2.1.1.байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэн баталж хэрэгжүүлэх;

7.2.1.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжилт, үр дүнд хяналт тавих;

7.2.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн шаардлага, стандарт, салбарын болон аж ахуйн нэгж, байгууллагын мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмын хэрэгжилтийн байдалд үзлэг, шалгалт хийлгэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;

7.2.1.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, үр дүнг тооцох, тайлагнах;

7.2.1.5.ажлын нөхцөл, мэргэжлийн онцлогт тохирсон тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг ажилтанд олгох, норм, чанар, зохистой хэрэглээнд хяналт тавих;

7.2.1.7.ажиллагсдыг эмнэлгийн нарийн мэргэжлийн бүрэн үзлэгт хамруулах, эрүүл мэндийн байдалд судалгаа хийх, эрүүлжүүлэх нөхөн сэргээх, сувилах ажлыг зохион байгуулах.

7.2.1.9.галаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, гал унтраах багаж хэрэгслийг хүрэлцээтэй авч байрлуулах, гал унтраах бүлгийг томилж сургууль, дадлага хийлгэх, галын эргүүл ажиллуулах.

7.2.1.10.ажилтан, албан тушаалтнуудын ХАБЭА-н талаар хүлээх үүрэг, хариуцлагыг ойлгуулах. Эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг арилгах дадлага, чадвар эзэмшүүлэх.

7.3.Улаанбаатар хотын музейн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

2.19.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах журмын хэрэгжилт, чиг үүргийг хангаж ажиллана.

Найм.Шалгалтын үр дүнг тооцох

8.1.Шалгалтын дүнг 2025 оны 10 дугаар сарын 15-ны дотор музейн удирдлага, захиргааны зөвлөлд танилцуулна.


8.2.Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг хууль, дүрэм, журмын хүрээнд авч хэрэгжүүлэх

8.3.Шалгалтын мөрөөр цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсруулж, музейн удирдлага, захиргаанд хүргүүлэх

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:



Б.ӨЛЗИЙБАЯР (Арга зүйч)



УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ
ХЯНАЛТЫН ХУУДАС

2025 оны 09 дүгээр сарын 23

Дугаар: 03 (2025)

Улаанбаатар хот

Музейн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журмын
хэрэгжилтэд үзлэг шалгалт хийх онооны хүснэгт

Д/д	ХАБЭА-н холбогдох хууль, журам	Шалгалт явуулах чиглэл: ХАБЭА-н холбогдох хууль, журмын заалтууд	Дүгнэлт (0-5 оноо)	
			Б.Өлзийбаяр	Б.Нарангэрэл
1.	ХАБЭА-н тухай хууль	14.1.Ажил олгогч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулна.		
2.		14.2.Энэ хуулийн 14.1-д заасны дагуу эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч хариуцна.		
3.		15.1.Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй.		
4.		26.2.Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшнээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна.		
5.		27.1.Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна.		
6.		27.2.Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна.		
7.		2.2.Музейн нь ХАБЭА-н орон тооны бус 2 ажилтныг захирлын тушаалаар томилж, ажиллуулна. ХАБЭА-н орон тооны бус ажилтан нь Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгж,		

		байгууллагын ХАБЭА-н зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам"-ыг жишиг болгон ХАБЭА-н ажилтны ажиллах журмыг боловсруулан баталж, мөрдөнө.		
8.		2.4.Тушаалаар томилогдсон ажилтан ХАБЭА-н холбогдох хууль тогтоомж, дүрэм, заавар стандарт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангуулж ажиллана.		
9.		7.1.1.8.Ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх;		
10.		7.1.1.9.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэх;		
11.		7.2.ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан дараах нийтлэг эдлэх эрх, үүрэг хүлээнэ. /ХАБЭА-н тухай хуулийн 27.3/ 7.2.1.Хүлээх үүрэг: 7.2.1.1.байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэн баталж хэрэгжүүлэх;		
12.		7.2.1.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжилт, үр дүнд хяналт тавих;		
13.	Музейн ХАБЭА-н журам	7.2.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн шаардлага, стандарт, салбарын болон аж ахуйн нэгж, байгууллагын мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмын хэрэгжилтийн байдалд үзлэг, шалгалт хийлгэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;		
14.		7.2.1.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, үр дүнг тооцох, тайлагнах;		
15.		7.2.1.5.ажлын нөхцөл, мэргэжлийн онцлогт тохирсон тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг ажилтанд олгох, норм, чанар, зохистой хэрэглээнд хяналт тавих;		
16.		7.2.1.7.ажиллагсдыг эмнэлгийн нарийн мэргэжлийн бүрэн үзлэгт хамруулах, эрүүл мэндийн байдалд судалгаа хийх, эрүүлжүүлэх нөхөн сэргээх, сувилах ажлыг зохион байгуулах		
17.		7.2.1.9.галаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, гал унтраах багаж хэрэгслийг хүрэлцээтэй авч байрлуулах, гал унтраах бүлгийг томилж сургууль, дадлага хийлгэх, галын эргүүл ажиллуулах		
18.		7.2.1.10.ажилтан, албан тушаалтнуудын ХАБЭА-н талаар хүлээх үүрэг, хариуцлагыг ойлгуулах. Эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг арилгах дадлага, чадвар эзэмшүүлэх		
19.	Музейн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө	2.19.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах журмын хэрэгжилт, чиг үүргийг хангаж ажиллана.		
Нийт оноо				
Дундаж оноо				

**УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ
ХЯНАЛТЫН ХУУДАС**

2025 оны 09 дүгээр сарын 25

Дугаар: 03 (2025)

Улаанбаатар хот

Музейн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журмын
хэрэгжилтэд үзлэг шалгалт хийх онооны хүснэгт

Д/д	ХАБЭА-н холбогдох хууль, журам	Шалгалт явуулах чиглэл: ХАБЭА-н холбогдох хууль, журмын заалтууд	Дүгнэлт (0-5 оноо)	
			Б.Өлзийбаяр	Б.Нарангэрэл
1.	ХАБЭА-н тухай хууль	14.1.Ажил олгогч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулна.	5	5
2.		14.2.Энэ хуулийн 14.1-д заасны дагуу эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч хариуцна.	5	5
3.		15.1.Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй.	4	3
4.		26.2.Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшнээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна.	5	5
5.		27.1.Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна.	5	5
6.		27.2.Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна.	5	5
7.		2.2.Музейн нь ХАБЭА-н орон тооны бус 2 ажилтныг захирлын тушаалаар томилж, ажиллуулна. ХАБЭА-н орон тооны бус ажилтан нь Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА-н зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам"-ыг жишиг болгон ХАБЭА-н ажилтны ажиллах журмыг боловсруулан баталж, мөрдөнө.	4	4
8.		2.4.Тушаалаар томилогдсон ажилтан ХАБЭА-н холбогдох хууль тогтоомж, дүрэм, заавар стандарт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангуулж ажиллана.	4	4

9.	Музейн ХАБЭА-н журам	7.1.1.8.Ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх;	3	3
10.		7.1.1.9.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэх;	0	0
11.		7.2.ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан дараах нийтлэг эдлэх эрх, үүрэг хүлээнэ. /ХАБЭА-н тухай хуулийн 27.3/ 7.2.1.Хүлээх үүрэг: 7.2.1.1.байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэн баталж хэрэгжүүлэх;	4	4
12.		7.2.1.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжилт, үр дүнд хяналт тавих;	4	4
13.		7.2.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн шаардлага, стандарт, салбарын болон аж ахуйн нэгж, байгууллагын мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмын хэрэгжилтийн байдалд үзлэг, шалгалт хийлгэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;	5	5
14.		7.2.1.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, үр дүнг тооцох, тайлагнах;	5	5
15.		7.2.1.5.ажлын нөхцөл, мэргэжлийн онцлогт тохирсон тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг ажилтанд олгох, норм, чанар, зохистой хэрэглээнд хяналт тавих;	4	3
16.		7.2.1.7.ажиллагсдыг эмнэлгийн нарийн мэргэжлийн бүрэн үзлэгт хамруулах, эрүүл мэндийн байдалд судалгаа хийх, эрүүлжүүлэх нөхөн сэргээх, сувилах ажлыг зохион байгуулах	4	4
17.		7.2.1.9.галаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, гал унтраах багаж хэрэгслийг хүрэлцээтэй авч байрлуулах, гал унтраах бүлгийг томилж сургууль, дадлага хийлгэх, галын эргүүл ажиллуулах	5	5
18.		7.2.1.10.ажилтан, албан тушаалтнуудын ХАБЭА-н талаар хүлээх үүрэг, хариуцлагыг ойлгуулах. Эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг арилгах дадлага, чадвар эзэмшүүлэх	3	3
19.	Музейн 2025 оны гүйцэтгэ- лийн төлөвлөгөө	2.19.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах журмын хэрэгжилт, чиг үүргийг хангаж ажиллана.	3	3
Нийт оноо			77	75
Дундаж оноо			4.05	3.19

ДУГНЭСЭН:  Б.ӨЛЗИЙБАЯР

(Арга зүйч)

 Б.НАРАНГЭРЭЛ

(Менежер)

УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ
ИЛТГЭХ ХУУДАС

2025 оны 09 дүгээр сарын 28

Дугаар (03)2025

Улаанбаатар хот

Музейн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журмын
хэрэгжилтэд үзлэг шалгалт хийсэн тухай

Музейн захирлын баталсан "Музейн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журмын хэрэгжилтэд үзлэг шалгалт хийх" удирдамжийн дагуу 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр арга зүйч Б.Өлзийбаяр, менежер Б.Нарангэрэл нар "Музейн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журам"-ын хэрэгжилтэд үзлэг шалгалт хийлээ.

Уг үзлэг шалгалтаар Монгол Улсын Засгийн газрын 2011 оны "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" 311 дүгээр тогтоол, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (цаашид ХАБЭА гэх)-н тухай хуулийн 14.1, 14.2, 15.1, 26.2, 27.1, 27.2 дахь заалтууд, Улаанбаатар хотын музейн ХАБЭА-н хяналтын журмын 2.2, 2.4, 7.1.1.8, 7.1.1.9, 7.2.1.1, 7.2.1.2, 7.2.1.3, 7.2.1.4, 7.2.1.5, 7.2.1.7, 7.2.1.9, 7.2.1.10 дахь заалтууд, Улаанбаатар хотын музейн захирлын 2024 оны "Журам батлах тухай" А/11 дүгээр тушаал, 2025 оны музейн дотоод хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөө, Улаанбаатар хотын музейн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг комиссын гишүүд мөрдлөг болгон ажиллав.

Музейн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журмын
хэрэгжилтэд үзлэг шалгалт хийсэн тухай хүснэгт

Д/д	ХАБЭА-н холбогдох хууль, журам	Шалгалт явуулах чиглэл: ХАБЭА-н холбогдох хууль, журмын заалтууд	Тайлбар
1.	ХАБЭА-н тухай хууль	14.1.Ажил олгогч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулна.	2024 оны 8 дугаар сард музей "Хурилдуур ХХК Шинонмед эмнэлэг"-тэй урьдчилсан сэргийлэх үзлэгийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан бүх ажилтнууд эрүүл мэндийн багц шинжилгээ, үзлэгт хамрагдсан. Хүн тус бүрд үзлэг хийж шинжилгээнд үндэслэн зөвлөгөө өгсөн. 2025 оны эрүүл мэндийн үзлэгийн тов хараахан гараагүй байна.
2.		14.2.Энэ хуулийн 14.1-д заасны дагуу эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч хариуцна.	2024 онд "Хурилдуур ХХК Шинонмед эмнэлэг"-тэй урьдчилсан сэргийлэх үзлэгийн үйлчилгээ үзүүлэх гэрээнд ажилтан тус бүрийн эрүүл мэндийн багц

			шинжилгээ, үзлэгийн үнэ болох 180 000 төгрөгийг музейн ХАБЭА зардлаас зарцуулсан.
3.		15.1.Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй.	Сан хөмрөгч, үзмэр харгалзагч, жижүүр зэрэг ажилтнуудыг нэг удаагийн хувцас хэрэглэлээр хангадаг. (Нэг удаагийн бээлий, халат, маск гэх мэт)
4.		26.2.Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшнээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна.	Тухайн жилийн батлагдсан төсвөөс нэг удаагийн хувцас, хэрэглэл, эмчийн үзлэг зэрэгт зарцуулан ажиллаж байна.
5.		27.1.Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна.	Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг музейн захирал хариуцан ажиллаж байна.
6.		27.2.Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна.	Музейн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний Б/13 дугаар тушаалаар байгууллагын ХАБЭА хариуцсан ахлах ажилтнаар С.Эрдэнэбат, гишүүнээр эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр нар томилогдон ажиллаж байна.
7.		2.2.Музейн нь ХАБЭА-н орон тооны бус 2 ажилтныг захирлын тушаалаар томилж, ажиллуулна. ХАБЭА-н орон тооны бус ажилтан нь Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА-н зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам"-ыг жишиг	"Улаанбаатар хотын музейн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журам"-ыг С.Эрдэнэбат боловсруулан 2024 оны 04 дүгээр сарын 10-нд музейн захирлаар батлуулсан байна.

		болгон ХАБЭА-н ажилтны ажиллах журмыг боловсруулан баталж, мөрдөнө.	
8.		2.4.Тушаалаар томилогдсон ажилтан ХАБЭА-н холбогдох хууль тогтоомж, дүрэм, заавар стандарт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангуулж ажиллана.	Музейн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний Б/13 дугаар тушаалаар байгууллагын ХАБЭА хариуцсан ахлах ажилтнаар С.Эрдэнэбат, гишүүнээр эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр нар томилогдон ХАБЭА-н холбогдох хууль тогтоомж, дүрэм, заавар стандарт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.
9.		7.1.1.8.Ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх;	ХАБЭА-н ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 1 дүгээр сарын 30-нд музейн захирлаар батлуулж төлөвлөгөөний дагуу "Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ"-г 4 дүгээр сард хийсэн байна.
10.		7.1.1.9.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэх;	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ огт хийлгэж байгаагүй.
11.	Музейн ХАБЭА-н журам	7.2.ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан дараах нийтлэг эдлэх эрх, үүрэг хүлээнэ. /ХАБЭА-н тухай хуулийн 27.3/ 7.2.1.Хүлээх үүрэг: 7.2.1.1.байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэн баталж хэрэгжүүлэх;	"Улаанбаатар хотын музейн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журам"-ыг С.Эрдэнэбат боловсруулан 2024 оны 04 дүгээр сарын 10-нд музейн захирлаар батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна.
12.		7.2.1.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжилт, үр дүнд хяналт тавих;	ХАБЭА-н ажилтан нь 2025 оны ХАБЭА-н төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.
13.		7.2.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн шаардлага, стандарт, салбарын болон аж ахуйн нэгж, байгууллагын мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмын хэрэгжилтийн байдалд	2025 оны музейн дотоод хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөөнд тусган ХАБЭА-н үйл ажиллагаанд үзлэг шалгалт хийж байна.

		үзлэг, шалгалт хийлгэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;	
14.		7.2.1.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, үр дүнг тооцох, тайлагнах;	МАОЭНХолбооны сургагч багш Р.Ганхуяг "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэс, ХАБЭА дахь ажилтны оролцоо" сэдэвт сургалтыг 2025 оны 9 дүгээр сарын 11-нд музейн бүх ажилтнуудад зохион байгуулсан.
15.		7.2.1.5.ажлын нөхцөл, мэргэжлийн онцлогт тохирсон тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг ажилтанд олгох, норм, чанар, зохистой хэрэглээнд хяналт тавих;	Сан хөмрөгч, үзмэр харгалзагч, жижүүр зэрэг ажилтнуудыг нэг удаагийн хувцас хэрэглэлээр хангадаг. (Нэг удаагийн бээлий, халат, маск гэх мэт)
16.		7.2.1.7.ажиллагсдыг эмнэлгийн нарийн мэргэжлийн бүрэн үзлэгт хамруулах, эрүүл мэндийн байдалд судалгаа хийх, эрүүлжүүлэх нөхөн сэргээх, сувилах ажлыг зохион байгуулах	2024 оны 8 сард музей "Хурилдуур ХХК Шинонмед эмнэлэг"-тэй урьдчилсан сэргийлэх үзлэгийн үйлчилгээ үзүүлэх гэрээнд ажилтан тус бүрийн эрүүл мэндийн багц шинжилгээ, үзлэгийн үнэ болох 180 000 төгрөгийг музейн ХАБЭА зардлаас зарцуулсан.
17.		7.2.1.9.галаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, гал унтраах багаж хэрэгслийг хүрэлцээтэй авч байрлуулах, гал унтраах бүлгийг томилж сургууль, дадлага хийлгэх, галын эргүүл ажиллуулах	Музейн галын аюулгүй байдлын журам боловсруулан музейн захирлын 2025 оны 07 дугаар сарын 05-ны А/30 дугаар тушаалаар батлуулсан. Мөн галын мэдээллийн самбар, галын аюул мэдээлэх хонх зэргийг худалдан авсан.
18.		7.2.1.10.ажилтан, албан тушаалтнуудын ХАБЭА-н талаар хүлээх үүрэг, хариуцлагыг ойлгуулах. Эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг арилгах дадлага, чадвар эзэмшүүлэх	2025 оны ХАБЭА-н ажлын төлөвлөгөөнд "Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ" хийхээр тусган эрсдэлийн үнэлгээ"-г 2025 оны 4 дүгээр сард хийсэн байна.
19.	Музейн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө	2.19.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах журмын хэрэгжилт, чиг үүргийг хангаж ажиллана.	ХАБЭА-н ажилтан нь 2025 оны ХАБЭА-н төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

ХАБЭА-н үзлэгийг комиссын гишүүд биечлэн үзэж танилцах, асуулт асуух, удирдамжид заасан хяналтын хэвлэмэл хүснэгтэд 0-5 оноогоор үнэлгээ хийж, гар тэмдэглэл хөтөлж ажиллав.

ХАБЭА хариуцсан ажилтан нь 2025 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:
 1.Эрхэс сувд ХХК-тай ХАБЭА-н ажилтны сургалтад албан хаагчийг хамруулах гэрээ байгуулж музейн дизайнер С.Эрдэнэбат 124 цагийн танхимын сургалтад хамрагдан амжилттай суралцан 2025 оны 1 сард сертификат авсан.



2.Музейн үзүүлэлтийн танхим, ариун цэврийн өрөөний барилгын засварын ажил хийгдэж байгаа орчинд тухай бүр үзлэг шалгалт явуулан, барилгын ажлыг гүйцэтгэж байгаа Гурвангис ХХК-ны ажилтнуудад холбогдох шаардлагыг тавьж албан бичиг илгээж ажилласан.

3.Музейн нийт ажилтнуудад музейн барилгын засвар хийх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгсөн. (2025 оны 06 дугаар сар)

4.МАОЭНХолбооны сургагч багш Р.Ганхуяг "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэс, ХАБЭА дахь ажилтны оролцоо" сэдэвт сургалтыг музейн бүх ажилтнуудад зохион байгуулсан. (2025 оны 09 дүгээр сар)



Хяналт шалгалтад комиссын гишүүдийн хяналтын хуудсанд өгсөн дундаж оноо 3.97 буюу 79.5%-ийн үнэлгээтэй гарсан нь музейн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажил "Дунд" түвшинд буйг илтгэж байна.

Үзлэг шалгалтаар илэрсэн зөрчлүүд болон зөрчлийг хэрхэн арилгах тухай:

- Музейн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журам"-ыг С.Эрдэнэбат боловсруулан 2024 оны 04 дүгээр сарын 10-нд музейн захирлаар батлуулсан боловч музейн захирлын тушаал шийдвэр байхгүй. Уг журам нь архив, бичиг хэргийн стандарт хангаагүй, үг үсгийн алдаатай, журмын зүйл, заалтын дугаарлалт алдагдсан, давхардсаныг музейн арга зүйч засварлан шинэчилснийг С.Эрдэнэбат музейн захирлаар дахин батлуулсан. ✓
- "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ" огт хийлгэж байгаагүй. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг стандартын асуудал эрхэлсэн

байгууллагын итгэмжлэл бүхий мэргэжлийн байгууллага Хөдөлмөрийн яамны сайдын 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/223 тоот тушаалын хавсралт "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам"-ын дагуу судалгаа явуулж төлөвлөгөө боловсруулан үе шаттайгаар зохион байгуулах (Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх зөвлөмжийг хавсаргав.)

- 2025 оны ХАБЭА-н ажлын төлөвлөгөөг 2025 оны 1 дүгээр сарын 30-нд музейн захирлаар батлуулсан байна. "Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ"г 4 дүгээр сард хийсэн боловч уг үнэлгээг хийх тушаал, шийдвэр байхгүй, үнэлгээний комисс томилоогүй, ХАБЭА ажилтан нь бие даан хийж товч тайлан бичсэн ба үнэлгээний явцад илэрсэн зөрчил, хэрхэн шийдвэрлэх тухай дүгнэлт, санал байхгүй тул 3 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй комисс томилон "Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ"-г Хөдөлмөрийн сайдын 2015 оны "Аргачилсан зөвлөмж батлах тухай" А/295 дугаар тушаалыг мөрдөж ажиллах ✓
- Музейн галын аюулгүй байдлын журам боловсруулан музейн захирлын 2025 оны 07 дугаар сарын 05-ны А/30 дугаар тушаалаар батлуулсан боловч уг журам нь архив, бичиг хэргийн стандарт хангаагүй, үг үсгийн алдаатай, журмын зүйл, заалтын дугаарлалт алдагдсан тул засвар хийж дахин боловсруулах
- ХАБЭА-н холбогдолтой батлагдсан хууль, дүрэм, журмыг хэвлэн авч хавтас үүсгэн өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах ✓
- Аюулын эрсдэлийг мэдээлэх хуудас бэлтгэн ашиглах
- Аюулгүйн ажиллагааны зааварчилгаа хэвлэж музейн танхим, ажилтнуудын өрөөнд байрлуулах

Энэ удаагийн үзлэгээр илэрсэн дээрх хүснэгтэд бичсэн зөрчлүүд болон зөрчлийг хэрхэн арилгах арга зүйтэй танилцан музейн захирлын дэргэдэх захиргааны зөвлөлөөр хэлэлцэн холбогдох мэргэжилтнүүдэд үүрэг өгч шийдвэрлэх шаардлагатай байна. ✓

Музейн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журмын хэрэгжилтэд үзлэг шалгалт хийсэн тухай ажлын тайланг 2025 оны 10 дугаар сарын 15-ны дотор Захирлын дэргэдэх Захиргааны зөвлөлд танилцуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг хууль, дүрэм, журмын хүрээнд авч хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:
ЗАХИРАЛ

ГИШҮҮН:

БОЛОВСРУУЛСАН:



П.ДАВААСҮРЭН

Б.НАРАНГЭРЭЛ
(Менежер)

Б.ӨЛЗИЙБАЯР (Арга зүйч)

АЖЛЫН БАЙРНЫ ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙЛГЭХ ЗӨВЛӨМЖ

Хууль эрх зүйн үндэслэл: Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5, 31 дүгээр зүйлийн 31.2-т "Ажил олгогч нь ажлын байр шинээр бий болгох болон тухайн ажлын байрны үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, нөхцөл өөрчлөгдөх бүрд нь химийн хорт болон аюултай бодис агуулсан түүхий эд, материал ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа бол жилд нэгээс доошгүй удаа ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг тус тус хийлгэнэ" гэж заасан.

"Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг стандартын асуудал эрхэлсэн байгууллагын итгэмжлэл бүхий мэргэжлийн байгууллага Хөдөлмөрийн яамны сайдын 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/223 тоот тушаалын хавсралт "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам"-ын дагуу хийнэ.

Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийх үйл ажиллагаа дэс дараалал:

- Иргэн, аж ахуй нэгж байгууллага нь "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үнэлгээ" хийлгэх хүсэлтээ ирүүлнэ.
- Ирүүлсэн хүсэлтийн дагуу ажлын байрны судалгааг гаргаж, хэмжилт шинжилгээний төлөвлөгөөг боловсруулна.
- Шаардлагатай тохиолдолд гэрээг байгуулан батлуулна.
- Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 07 сарын 16-ны өдрийн 102 дугаар тушаалын хавсралт "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд хийх үнэлгээний тариф"-ын дагуу хэмжилт, шинжилгээний төлбөрийг тооцно.
- Хэмжилт, шинжилгээг хийх: Төлөвлөгөөний дагуу ажлын байрнуудад хэмжилт, шинжилгээг хийж гүйцэтгэнэ.
- Дүгнэлт, зөвлөмж боловсруулах: Хэмжилт шинжилгээний үр дүнг боловсруулан холбогдох стандарттай харьцуулан үнэлж улсын байцаагчийн дүгнэлт, зөвлөмжийг гаргана.
- Хяналт, шинжилгээний дүнг хүлээлгэн өгөх: Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийсэн тухай дүгнэлт, зөвлөмжийг хүсэлт гаргагч байгууллагад танилцуулан хүлээлгэн өгнө.